

**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2022 оны 05 дугаар сарын
22-ны өдөр

Дугаар А/237, А/137

Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх салбар дундын үйл ажиллагааны төлөвлөгөө” /2022-2025/ -г хавсралтаар баталсугай.
2. Бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх салбар дундын үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах орон тооны бус хамтарсан зөвлөл байгуулан, хагас жил тутам хэрэгжилтийг хэлэлцэж, холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудыг мэдээллээр хангаж ажиллахыг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар /Д.Нарантуяа/, Мал эмнэлгийн ерөнхий газар /Д.Батчулуун/ -т даалгасугай.
3. “Бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх салбар дундын үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Ц.Эрдэмбилэг/, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Г.Жамбалцэрэн/ нарт тус тус үүрэг болгосугай.
4. “Бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх салбар дундын үйл ажиллагааны төлөвлөгөө”-г хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг байгууллагынхаа төсөвт тусган хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг эрүүл мэндийн болон мал эмнэлгийн салбарын байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

С.ЭНХБОЛД

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД

З.МЭНДСАЙХАН

Эрүүл мэндийн сайд,
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн
үйлдвэрийн сайдын
хамтарсан 2022 оны 02
сарын 02 өдрийн А/М.А/137
дугаар тушаалын хавсралт

**БИЧИЛ БИЕТНИЙ ТЭСВЭРЖИЛТЭЭС СЭРГИЙЛЭХ САЛБАР
ДУНДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ
(2022-2025)**

Нэг. Өнөөгийн байдал:

2011 онд Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-аас “Бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх арга хэмжээ авах тухай” 6 үндсэн чиглэлийг батлан, гишүүн орнуудыг энэ чиглэлд үйл ажиллагаагаа хандуулахыг уриалсан. Энэ хүрээнд 2014 онд ДЭМБ-аас бичил биетний эсрэг эмэнд үүсэж буй тэсвэржилтийн тандалт судалгааг олон улсын төвшинд хийж улс орнуудад гол тулгарч буй бэрхшээлийг тодорхойлсон байна. Үүнд: Улс орнуудад эмэнд бичил биетний тэсвэржилт үүсэхээс сэргийлэх цогц бодлого дутмаг, антибиотик эмийн хэрэглээ, түүнд үүсэж буй тэсвэржилтийг хянах тогтолцоо үндэсний болон бүсийн төвшинд хомс, бичил биетний эсрэг эмийн тэсвэржилтээс сэргийлэх хариу арга хэмжээ авах тогтолцоо эрүүл мэндийн байгууллагуудад сул байгааг онцолсон. Иймээс 2014, 2015 онд Бичил биетний тэсвэржилттэй тэмцэх бүсийн болон дэлхийн төлөвлөгөөг ДЭМБ-аас батлан хэрэгжүүлж байна.

Бичил биетний тэсвэржилтийг зогсоохын тулд улс орнууд уламх үчээ нэгтгэн ажиллах шаардлагатай байгааг ДЭМБ-ын Номхон далайн баруун эргийн бүсийн хорооны чуулганаар 2020 онд баталсан “Бичил биетний тэсвэржилттэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх үйл ажиллагааны хүрээ”-нд онцлон дурьдаж, Нэг бүс-Нэг хөдөлгөөнийг өрнүүлж эхэлсэн. Энэхүү үйл ажиллагааны хүрээ нь улс орнуудыг тогтвортой, ирээдүйг харсан гарц шийдлүүдийг нийгмийн өргөн хүрээний оролцоо, хөдөлгөөнөөр дамжуулан нөхцөл байдал, хэрэгцээнд уялдуулсан арга хэмжээгээр хэрэгжүүлэх саналыг дэвшүүлсэн. (1,2)

Өнөөдөр дэлхийн хэмжээнд мал аж ахуйн салбарт хэрэглэж байгаа антибиотикийн нийт хэрэглээний 80 хувийг эмчилгээний зорилгоор бус харин малын өсөлтийг дэмжих зорилгоор малын тэжээлд хольж хэрэглэж байгаа бөгөөд антибиотикийн шимэгдээгүй үлдэгдэл малаас гаргаж авах хүнсний бүтээгдэхүүнүүдээр дамжин хүний биед бичил биетний тэсвэржилтийг нэмэгдүүлж байгаа гол хүчин зүйл болоод байна. Тухайлбал, 2010 оны байдлаар дэлхийн хэмжээнд 63.2 мянган тонн антибиотикийг малын тэжээлд нэмэлтээр хэрэглэж байсан бол энэ тоо 2030 он гэхэд 105.6 мянган тонн болж өсөх хандлагатайг НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас онцолж байна.(3)

Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарт антибиотикийн хэрэглээ асар өндөр байгаа нь ирээдүйд хүний эрүүл мэндийн салбарт хамгийн том сорилтыг бий болгоход нөлөөлөх гол хүчин зүйлсийн нэг болж байна.

Бичил биетний эсрэг эмийг зохисгүй хэрэглэснээр тэсвэржилт үүсдэг. Үүний хор уршиг нь хувь хүн, эрүүл мэндийн байгууллага, эдийн засагт сөргөөр нөлөөлдөг. Хувь хүн тэсвэржсэн бичил биетний халдвараар өвдсөн үед халдвар эмчлэгдэхгүй удах, эмийн гаж нөлөө ихсэх, улмаар амь насаа алдах аюул учирдаг. Эрүүл мэндийн байгууллагад халдварыг эмчлэхэд бэрхшээл учирч, эмийн сонголтгүй болох, эрүүл мэндийн зардал өсөх зэрэг асуудлууд гардаг. Иймд бичил биетний эсрэг эмийн зохистой хэрэглээг хангахын тулд иргэд, эрүүл мэндийн байгууллага, засгийн газар хамтран хичээж, хариуцлагатай хандах шаардлагатай юм.

Дэлхий дээр сүүлийн 30 гаруй жилийн хугацаанд нянгийн эсрэг шинэ эм буюу антибиотикийг шинээр огт нээж илрүүлээгүй байгаа тул хүн төрөлхтний хэрэглээнд байгаа тодорхой тооны эмэнд бичил биетнүүд тэсвэржиж, улмаар тэсвэржсэн бичил биетний эсрэг хэрэглэх эм улам бүр ховордож байгаа билээ.

2018 оны байдлаар дэлхийн хэмжээнд хорт хавдар, чихрийн шижин, осол гэмтлийн шалтгаант нас баралтууд тэргүүн байруудыг эзэлж байсан бол 2050 он гэхэд “супер бактери” буюу антибиотикт тэсвэржсэн супер нянгийн шалтгаант нас баралт дэлхийн хэмжээнд нас баралтын тэргүүлэх шалтгаан болж 1 жилд 10 сая хүн эмчилгээнд хэрэглэх антибиотикийн сонголтгүй болсны улмаас амь насаа алдахад хүрнэ гэдгийг тооцоолсон байна.(4)

ДЭМБ-аас эмэнд тэсвэржиж буй бичил биетэнтэй тэмцэх зорилгоор антибиотикийн хэрэглээ, бичил биетний тэсвэржилтийн тулгамдсан асуудлуудыг зохистойгоор шийдвэрлэхийн тулд улс орнуудад “Бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх салбар дундын үндэсний төлөвлөгөө”-г боловсруулахыг зөвлөмж болгосон.(1, 2)

Хоёр. Төлөвлөгөө боловсруулан гаргах үндэслэл:

Нийгмийн эрүүл мэнд буюу эрүүл мэндийн салбарт бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх үйл ажиллагаанд баримтлах стратеги тодорхой бөгөөд үүнд антибиотикийн шаардлагагүй хэрэглээг бүрэн зогсоох, халдварт өвчний тархалтыг бууруулах замаар бичил биетний эсрэг үйлдэлтэй эмийн хэрэглээг бууруулах, эмийг хэрэглэх тохиолдолд тухайн халдварт тохирсон эмийг зөвхөн эмчийн заасан дэглэмийн дагуу зөв хэрэглэх дадлыг төлөвшүүлэх зэрэг нь хамгийн үр дүнтэй аргууд болохыг ДЭМБ-аас баталсан “Бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх үйл ажиллагааны дэлхийн стратеги”-д тодорхой заасан байдаг.(5) Уг стратегид зааснаар нийгмийн эрүүл мэндийн салбарт

- 1) Ард иргэдийн ойлголт, мэдлэгийг сайжруулах,
- 2) Тэсвэржсэн бичил биетний тандалт судалгааг эрчимжүүлэх,
- 3) Халдварын тархалтыг бууруулах,
- 4) Бичил биетний эсрэг эмийн хэрэглээнд хяналт тавих,

5) Бичил биетний эсрэг шинэ эм гаргаж авах судалгаа шинжилгээний ажилд оруулах хөрөнгө оруулалтыг тасалдуулахгүй байх гэсэн 5 чиглэлээр онцлон анхаарч ажиллахыг чиглэл болгосон ба манай улс ДЭМБ-ын гишүүн улсын хувьд дээрх стратегийн эхний 4 чиглэлийг мөрдлөг болгон ажиллаж, тодорхой үр дүнд хүрч байгаа.

Үндэсний хэмжээний антибиотик эмийн хэрэглээ, тэсвэржилтийн талаар судалгаа одоогийн байдлаар хангалттай бус байна. ДЭМБ-тай хамтран 2019 онд Монгол улсын антибиотикийн хэрэглээний судалгааг хийсэн бөгөөд манай улсын импортлосон болон үйлдвэрлэсэн антибиотик эмийн хэрэглээ нь 1000 хүн ам тутамд тооцоход 50.7 өдрийн тун (ӨТ) (6) байсан. Энэ нь 2015 оныхтой харьцуулахад 21.3%-р буурсан үзүүлэлт байлаа (6, 7). Улсын эмнэлгүүдэд антибиотикийн хэрэглээг 5 жилийн дунджаар тооцоход 199-420 ӨТ/100 ор хоног байсан.(8) Эдгээр үзүүлэлтүүдийг бусад улсуудтай харьцуулахад Монгол улсын антибиотик эмийн хэрэглээ өндөр байгаа юм.(9)

2021 оны 11 сарын байдлаар 4232 эм манай улсад бүртгэлтэй байгаа бөгөөд эдгээрийн 471 буюу 11% нь антибиотик байна. Үүнээс 31 нэр төрөл нь дотоодын үйлдвэрийнх, 440 нэр төрөл нь импортын нянгийн эсрэг эм байна.(10)

Эмийн нэр төрлөөр нь авч үзвэл амоксациллин болон амоксациллин/клавуланы хүчлийн хэрэглээ хамгийн өндөр байсан. 2020 онд Эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлттэй үнийн тарифаар 0-19 насны иргэд амоксациллин нэрийн эмийг 168,971,238 төгрөгөөр 25,092 (38.8%) удаагийн худалдан авалт хийсэн нь хамгийн өндөр хувийг эзэлж байна.(11) Дэлхий дахиныг хамарсан цар тахлаас хамааран 2020, 2021 онуудад макролид, фторхинолин болон карбапенемийн бүлгийн эмийн хэрэглээ өмнөх жилүүдтэй харьцуулахад нэмэгдсэн.(11) Эдгээр нь ДЭМБ-ын зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтын “хэрэглээг хянах” бүлэгт хамаардаг бөгөөд үүний үр дагавар нь олон эмэнд тэсвэржсэн нянгаар үүсгэгдсэн халдварыг ирээдүйд бий болгох эрсдэлтэй.(12)

2021 онд Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газраас явуулсан “Иргэдийн эмийн зохистой хэрэглээний талаарх мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэх” судалгааны дүнгээс харахад иргэдийн амьдарч буй байршлаас хамааран эмийн зохистой хэрэглээний талаарх мэдээлэл авах нь хязгаарлагдмал байна.(13) Мөн эмч нар эмчилгээнд бичил биетний эсрэг эмийг сонгоход нян судлалын шинжилгээний хариу удаж гардаг нь бэрхшээлтэй байдаг гэсэн дүгнэлт гарсан. Судалгаанд оролцогчдын зөвхөн 1/3 буюу 34.0% нь эмийн зохистой хэрэглээний мэдлэгтэй, 5 хүний нэг нь зохистой хандлагатай байв(13).

Цаашид хүний эрүүл мэндийн салбарт тэсвэржсэн бичил биетний тандалтыг идэвхитэй хийж, үндэсний төвшинд бичил биетний тэсвэржилтийн мэдээг нэгтгэх, дүн шинжилгээ хийх, олон улстай мэдээллээ солилцох, халдварт өвчний тархалтыг бууруулах ажлыг эрчимжүүлэх, нийтийн үйлчилгээтэй эмийн сангаас антибиотикийг жоргүй олгохыг бүр мөсөн таслан зогсоох, Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлттэй олгож буй антибиотикийн хэрэглээг цахим жороор бүрэн хянах, хүн ам, малчид, тариаланчдын мэдлэг хандлагыг өөрчлөх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагууд байна.

Монгол улсад 2018 оноос эхлэн хэрэгжиж буй “Мал, амьтны эрүүл мэндийн тухай”(14) хуулийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлж эхэлсэн нь Монгол улсад бичил биетний тэсвэржилттэй тэмцэх төлөвлөгөөг хэрэгжүүлэх угтвар нөхцөлийг бүрдүүлсэн болно.

Монгол улсын хувьд 2013 оноос эхлэн Антибиотикийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, эмэнд нянгийн тэсвэржилт үүсэхээс сэргийлэх стратеги /2013-2017/(15), Эрүүл мэндийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2017 оны А/191, А/64 дүгээр хамтарсан тушаалаар баталсан “Нянгийн тэсвэржилтээс сэргийлэх салбар дундын үйл ажиллагааны төлөвлөгөө /2017-2020/”(16)-г хэрэгжүүлээд байгаа бөгөөд одоогоор салбар дундын стратегийн хэрэгжилтийг үнэлсэн.

Дээрхи Нянгийн тэсвэржилтээс сэргийлэх салбар дундын төлөвлөгөө (НТССДТ)-нд 6 чиглэлийн нийт 69 үйл ажиллагааг хийж хэрэгжүүлэхээр тусгагдсан. Түргэвчилсэн үнэлгээнээс харахад бүрэн биелсэн 40 (58%), хагас биелэлттэй 20 (29%), биелээгүй 9 (13%), хэрэгжилтийн хувь 86.9% байна. Салбар дундын хамтын ажиллагаа, мөн хөдөө аж ахуйн салбарт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн зарим үйл ажиллагаанууд хангалттай бус байна.

Цаашид энэхүү төлөвлөгөөг шинэчлэн дараагийн шатны арга хэмжээнүүдийг авах зайлшгүй шаардлагатай.

Гурав. Төлөвлөгөөний зорилго

Бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх үндэсний төлөвлөгөөний зорилго нь хүний болон малын эрүүл мэндэд нөлөөлж буй эмэнд тэсвэртэй бичил биетнийг тандах, түүнтэй тэмцэх, халдвараас урьдчилан сэргийлэх, нянгийн эсрэг эмийн хэрэглээг хянах, бичил биетний тэсвэржилтийн талаархи хүн ам болон хүн, малын эрүүл мэндийн салбарын ажилтны мэдлэг хандлагыг сайжруулж, зохистой хэрэглээг төлөвшүүлэхэд оршино.

Дөрөв. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилт

1. Салбар дундын үйл ажиллагааг хангах орон тооны бус зөвлөлийг байгуулж, жил бүр хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавьж, бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх засаглалын механизмыг сайжруулах.
2. Бичил биетний тэсвэржилтийн илрүүлэлт, тандалтыг сайжруулж, бичил биетний тэсвэржилтийн мэдээллийг үндэсний төвшинд нэгтгэх, дүн шинжилгээ хийх, мэдээлэх чадавхийг бэхжүүлэх.
3. Бичил биетний эсрэг эмийн хэрэглээг хянах, зохисгүй хэрэглээг бууруулах, эрүүл мэндийн байгууллагын бичил биетний тэсвэржилттэй тэмцэх хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх замаар хариуцлагатай хэрэглээг бий болгох.

4. Халдварын сэргийлэлт, хяналтыг сайжруулан, байгаль орчны бохирдлоос сэргийлэх арга хэмжээ авч, халдварын тархалтыг зогсоох.
5. Бичил биетний тэсвэржилтийн талаарх мэдээллийг олон нийтэд түгээх, боловсролын хөтөлбөрт оруулах, мэдлэг хандлагыг дээшлүүлэх, зохистой дадлыг сайжруулах замаар бичил биетний тэсвэржилтээс урьдчилан сэргийлэх, бууруулах.

Тав. Төлөвлөгөө хэрэгжсэнээр хүлээгдэж буй үр дүн

№	Чиглэл	Одоогийн суурь түвшин	Хүлээгдэж буй үр дүнгүүд
1	Засаглал	Тогтмол үйл ажиллагаатай, салбар дундын бүтэц байхгүй	Салбар дундын зөвлөл байгуулж жилд 2-оос доошгүй удаа хуралдаж үйл ажиллагаа тогтворжсон байна.
2	Тандалт, сэргийлэлт	Суурь судалгаа байхгүй	Төлөвлөгөөний дагуу үндэсний мэдээлэлтэй болж GLASS-т нэгдсэн байна.
3	Бичил биетний эсрэг эмийн хэрэглээ	Импорт (одоогийн түвшин 37 DID), ЭМДС-аас олгогдох эмийн хэрэглээг хянаж байна. Малын эмийн хэрэглээний суурь мэдээлэл байхгүй.	Импортын ББЭЭ-ийн хэрэглээний дүн 10%-аас доошгүй хувиар буурсан байна.(27 DID) Эрүүл мэндийн байгууллагад хэрэглэж буй, ЭМДС-аас хөнгөлттэй олгох ББЭЭ-ийн хэрэглээг WHO ATC/DDD аргачлалын дагуу AWARE ангиллаар гаргаж мэдээлнэ. Малын эмийн хэрэглээний суурь мэдээлэлтэй болсон байна.
4	Халдварын сэргийлэлт	Суурь мэдээлэл байхгүй.	Эмнэлгээс шалтгаалсан халдварын суурь мэдээлэлтэй болно.
5	Мэдээлэл, сургалт, сурталчилгаа	Антибиотикийн дэлхийн 7 хоног, Анагаахын чиглэлээр төгсөлтийн дараах сургалт	ДЭМБ-ын тэмдэглэлт 5-аас доошгүй үйл ажиллагаа Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр, хөдөө аж ахуйн салбарын сургалтын хөтөлбөрт оруулсан байна.

Зургаа. Хяналт, үнэлгээ

Эрүүл мэндийн болон малын эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцан холбогдох байгууллагуудыг оролцуулан явцын болон төгсгөлийн үнэлгээг хийж гүйцэтгэнэ.

Мэдээллийн эх сурвалжууд

1. World Health Organization. Antimicrobial resistance: a manual for developing national action plans. 2016.
2. World Health Organization. Country progress in the implementation of the Global Action Plan on Antimicrobial Resistance: WHO, FAO and OIE global tripartite database. World Health Organization Available from: <http://www.who.int/antimicrobial-resistance/global-action-plan/database/en/> [Last accessed on 2018 Apr 12]. 2018.
3. Food and Agriculture Organization. The FAO Action Plan on Antimicrobial Resistance 2021–2025. FAO Rome, Italy; 2021.
4. Murray CJ, Ikuta KS, Sharara F, Swetschinski L, Aguilar GR, Gray A, et al. Global burden of bacterial antimicrobial resistance in 2019: a systematic analysis. The Lancet. 2022.
5. World Health Organization. Global action plan on antimicrobial resistance. WHO Report. 2015.
6. Монгол улс, Эрүүл мэндийн яам. Антибиотик эмийн тандалт судалгаа 2019.
7. Dorj G, Dembereldorj B, Chojoo A, Enkhee E, Sanjjav T, Blix HS. National surveillance of antibiotic consumption in Mongolia. International Journal of Infectious Diseases. 2020;101:96.
8. Dorj G, Salvesen Blix H, Sunderland B, Gankhulug B, Tegshee O, Purevkhoo M, et al. Antibiotic utilization trends in two state hospitals of Mongolia from 2013 to 2017. BioMed Research International. 2019;2019.
9. World Health Organization. Antimicrobial consumption in the WHO Western Pacific Region: early implementation of the Western Pacific Regional Antimicrobial Consumption Surveillance System (WPRACSS). 2021.
10. Монгол улс, Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар "Монгол улсын эм зүйн салбарын үзүүлэлт 2021".
11. Монгол улс, Эрүүл мэндийн даатгалын сан. Эрүүл мэндийн даатгалын хөнгөлттэй эм. 2020.
12. World Health Organization. 2021 AWaRe classification. 2021.
13. Монгол улс, ЭЭХХЗГ, Иргэдийн эмийн зохистой хэрэглээний талаарх мэдлэг, чадвар, хандлагын судалгаа. 2021.
14. Монгол улс. Мал, амьтны эрүүл мэндийн тухай. 2018.
15. Монгол улс. Антибиотикийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, эмэнд нянгийн тэсвэржилт үүсэхээс сэргийлэх стратеги /2013-2017/. 2013.
16. Монгол улс. Нянгийн тэсвэржилтээс сэргийлэх үйл ажиллагааны салбар дундын төлөвлөгөө /2017-2020/. 2017.

Товчилсон үгийн тайлбар:

АНМЭГ - Аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газар

АНЭМГ - Аймаг, нийслэлийн эрүүл мэнд газар

АШУҮИС- Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль

ББТ- Бичил биетний тэсвэржилт

ББЭЭ- Бичил биетний эсрэг эм

БОАЖЯ – Байгаль орчин, аялал жуулчлалын яам

БШУЯ – Боловсрол шинжлэх ухааны яам

ГЕГ – Гаалийн ерөнхий газар

ДМАЭМБ – Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллага

ДЭМБ - Дэлхийн эрүүл мэндийн байгууллага

ЗӨСҮТ – Зоонозын өвчин судлалын үндэсний төв

МХЕГ - Мэргэжлийн хяналтын ерөнхий газар

МЭЕГ - Мал эмнэлгийн ерөнхий газар

МЭХ- Мал эмнэлгийн хүрээлэн

МЭЭСБУЛ – Мал эмнэлгийн эмийн сорилын баталгаажуулалтын улсын лаборатори

НЭМҮТ- Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв

ОУБ- Олон улсын байгууллага

ӨАУМХ- Өрхийн анагаах ухааны мэргэжилтнүүдийн холбоо

САЗ – Стандарт ажиллагааны зааварчилгаа

СХЗГ- Стандарт, хэмжил зүйн газар

ТББ- Төрийн бус байгууллага

УХЭШХ- Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн

УМЭАЦТЛ- Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лаборатори

ХААИС- Хөдөө, аж ахуйн их сургууль

ХАБҮЛЛ- Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори

ХӨСҮТ - Халдварт өвчин судлалын үндэсний төв

ХХААБ - НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага

ХХААХҮЯ – Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам

ЭМДЕГ – Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар

ЭМЯ – Эрүүл мэндийн яам

ЭЭХХЗГ- Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар

ЭМХТ- Эрүүл мэндийн хөгжлийн төв

Бичил биетний тэсвэржилттэй тэмцэх салбар дундын үйл ажиллагааны төлөвлөгөө /2022-2025/-ний төсөл

д/д	Үйл ажиллагаа	Он				Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Хэрэгжүүлэгч байгууллага	Хамтрагч
		2022	2023	2024	2025				
1. Зорилт 1 : Салбар дундын үйл ажиллагааг хангах орон тооны бус зөвлөлийг байгуулж, жил бүр хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавьж, бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх засаглалын механизмыг сайжруулах.									
1.1	Бичил биетний тэсвэржилт/ББТ/-тэй тэмцэх төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах салбар дундын орон тооны бус зөвлөл байгуулах	+	+	+	+	Зохион байгуулагдсан хурлын шийдвэр	7-аас доошгүй удаагийн хамтарсан хурлаар хагас жил тутам хэрэгжүүлсэн үйл ажиллагааг хэлэлцсэн байна.	ЭЭХХЗГ, МЭЕГ	ЭМЯ, ХХААХҮЯ, ДЭМБ, ХХААБ, БШУЯ, БОАЖЯ, Кодекс /Codex/ үндэсний зөвлөл
1.2	Хүний болон малын эмийн зөвлөлөөр жил тутам Бичил биетний эсрэг эм /ББЭЭ/-ийн тэсвэржилт, хэрэглээний дүнг хэлэлцэж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар зөвлөмж, шийдвэр гаргах	+	+	+	+	Хурлаар хэлэлцүүлсэн асуудлын тоо	4-өөс доошгүй удаагийн хурлаар ББТ, ББЭЭ-ийн хэрэглээний дүнг танилцуулсан байна.	ЭЭХХЗГ, МЭЕГ	Хүний эмийн зөвлөл, Малын эмийн зөвлөл

1.3	ББТ-тэй салбар дундын үйл ажиллагааны төлөвлөгөөнд шаардагдах зардлыг тухайн жилийн байгууллагынхаа төсөвт тусгаж, үйл ажиллагааг хэрэгжүүлэх	+	+	+	+	Шардлагатай төсвийг санхүүжүүлсэн байгууллагын тоо	Байгууллагын жилийн төсөвт хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг тусгасан байна.	Хэрэгжүүлэгч байгууллагууд	ЭМЯ, ХХААХҮЯ
1.4	ББТ-тэй тэмцэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн явцын хөндлөнгийн үнэлгээг хийх	-	+	-	+	Хийгдсэн үнэлгээний тоо	Дунд хугацааны болон эцсийн үнэлгээг хийж зөвлөмж, дүгнэлт гарсан байна.	Салбар дундын зөвлөл	ЭМЯ, ХХААХҮЯ, ЭЭХХЗГ, МЭЕГ, ДЭМБ, НҮБ-ын ХХААБ
1.5	ББТ-ийг хянах, сэргийлэх үндэсний чуулганыг зохион байгуулах	-	+	+	+	Зохион байгуулсан чуулган, зөвлөгөөний тоо	Үндэсний хэмжээнд 250-аас доошгүй төлөөлөл оролцсон байна.	Салбар дундын зөвлөл	ЭМЯ, ХХААХҮЯ, ЭЭХХЗГ, МЭЕГ, ДЭМБ, НҮБ-ын ХХААБ, /ДМАЭМБ/
1.6	ББТ-ийн талаарх шалгуурыг хүний болон малын эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэл, гүйцэтгэлийн үнэлгээнд оруулах	-	+	+	+	Шалгуурт орсон заалт	ББЭЭ-ийн эмчилгээний удирдамжтай болж, лаборатори нь WHONET сүлжээнд мэдээллээ илгээдэг болсон байна.	ЭМЯ, ЭМХТ	Эрүүл мэндийн байгууллагууд, Стандарт, хэмжил зүйн газар

1.7	ББТ-тэй чиглэлээр олсон хөдөлгөөн, улсын сүлжээнд нэгдэх, харилцан мэдээлэл, туршлага солилцох	+	+	+	+	Оролцсон хурал, зөвлөгөөний тоо	5-аас доошгүй удаа гадаад оронд ББТ-ийн чиглэлээр үйл ажиллагаанд оролцсон байна.	ЭМЯ, ХХААХҮЯ, ЭЭХХЗГ, МЭЕГ, ХӨСҮТ	ДЭМБ, НҮБ-ын ХХААБ, ДМАЭМБ
1.8	Хүнсээр дамжих ББТ-тэй холбогдох кодексийн стандартыг орчуулах, СХЗГ-ын Техникийн хороо болон олон нийтээр хэлэлцүүлэн баталгаажуулах	-	+	-	+	Орчуулсан кодексийн тоо	Кодексын 2 удирдамж, дадлын дүрэм 1-ийг орчуулан хэлэлцүүлж, батлуулсан байна.	ХХААХҮЯ, НҮБ-ын ХХААБ	СХЗГ, МЭЕГ
1.9	Эмийн эмчилгээг зохицуулах хорооны журамд нэмэлт өөрчлөлт оруулах	+	+	-	-	Батлагдсан журам	ЭМ-ийн сайдын тушаал батлагдсан байна.	ЭЭХХЗГ	Эрүүл мэндийн байгууллагууд
1.10	Хүнс, хөдөө аж ахуйн салбарт ББЭЭ болон ББТ-ийн талаар хэрэгжиж буй эрх зүйн баримт бичигт үнэлгээ хийх	-	+	-	+	Үнэлгээний тайлан, зөвлөмж	Үнэлгээний дүнд үндэслэсэн дүгнэлт, зөвлөмж гарсан байна.	МЭЕГ	ХХААХҮЯ, МЭЕГ, БОАЖЯ, МХЕГ, ОУБ
Зорилт 2: Бичил биетний тэсвэржилтийн илрүүлэлт, тандалтыг сайжруулж, бичил биетний тэсвэржилтийн мэдээллийг үндэсний төвшинд нэгтгэх, дүн шинжилгээ хийх, мэдээлэх чадавхийг бэхжүүлэх.									

2.1	ББТ-ийн илрүүлэлт, тандалтын журам, ББТ-ийг мэдээлэх, оролцогч байгууллагуудын үйл ажиллагааны чиг үүргийг тодорхойлсон стандарт ажиллагааны заавар, шийдвэр гаргагчид болон эрүүл мэндийн байгууллагад мэдээлэх журмыг боловсруулж, батлуулах	-	+	+	+	-	Батлагдсан журмын тоо	2	ХӨСҮТ, МЭЕГ	ЭМЯ, ХХААХҮЯ, ЭЭХХЗГ, Олон улсын байгууллага /ОУБ/
2.2	Хүн болон мал эмнэлгийн лабораторид суурилсан ББТ-ийн тандалтын судалгаа хийх	+	+	+	+	+	Судалгааны тоо	Судалгааны дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж гарсан байна.	ХӨСҮТ, МЭЕГ	АШУУИС, МЭХ, Аймаг, нийслэлийн эрүүл мэнд, мал эмнэлгийн газар, ОУБ
2.3	Антибиотикийн мэдрэг чанар, ББТ-ийг тодорхойлох шинжилгээний удирдамж, САЗ, боловсруулж батлуулах	-	+	+	-	-	Шинээр нэвтэрсэн шинжилгээний аргачлалын тоо	Удирдамж, САЗ батлагдсан байна.	ХӨСҮТ, МЭЕГ	АШУУИС, МЭХ, УМЭАЦЛ, МЭЭСБУЛ

2.4	Эмнэлгийн цахим мэдээллийн тогтолцоо /HIS, LIS/-нд WHONET программыг холбон, мэдээлэл солилцох боломжийг судлах	+	+	-	-	Судалгааны тайлан, зөвлөмж	Програмуудыг холбох санал гарсан байна.	ЭМЯ, ЭМХТ, эмнэлгүүд	
2.5	НҮБ-ын ХХААБ-ын "ATLASS" аргачлалыг ашиглан ХХАА-н салбарын лабораториудад ББТ-ийн тандалтын чадавхи, нөхцөл байдлын үнэлгээ хийх	+	-	-	-	Үнэлгээний тайлан	БТ-ийн тандалтын чадавхи, нөхцөл байдлын үнэлгээ хийгдсэн байна.	МЭЕГ, УМЭАЦТЛ, МЭХ, МЭЭСБУЛ, ХАБУЛЛ, ХӨСҮТ	ХХААХҮЯ, НҮБ-ын ХХААБ
2.6	ББТ-ийн тандалтын дэлхийн сүлжээ (GLASS, WHONET)-д хүн болон мал эмнэлгийн нян судлалын лабораторийг хамруулах зорилгоор ОУБ-аас зөвлөх урьж, сургалт зохион байгуулах	-	+	+	-	Зохион байгуулсан сургалтын тоо, зөвлөхийн тайлан	Лабораторийн мэргэжилтнүүд сургалтад хамрагдсан байна.	ЭМЯ	ЭЭХХЗГ, ХӨСҮТ, ЗӨСҮТ, МЭХ, НЭМҮТ, хүний болон мал эмнэлгийн лабораториуд

2.7	ББТ-ийн мэдээллийг үндэсний хэмжээнд нэгтгэх, дүн шинжилгээ, хяналт хийх, эргэн мэдээллэх чадавхийг бий болгох	-	+	+	+	+	Сургалтад хамрагдсан мэргжилтний тоо	Жил бүр 1-ээс доошгүй удаа сургалтыг зохион байгуулж, мэдлэгийг олгосон байна.	ХӨСҮТ, МЭЕГ	ЭМЯ, ХХААХҮЯ, ЭЭХХЗГ
2.8	ББТ-ийн WHONET үндэсний сүлжээг өргөжүүлэн аймаг, дүүргийн эмнэлгийн лабораториудыг үе шаттайгаар хамруулах	+	+	+	+	+	Сүлжээнд нэгдсэн эрүүл мэндийн байгууллагуудын тоо	Төв эмнэлэг, тусгай мэргэшлийн төв, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгүүд бүрэн WHONET сүлжээнд холбогдсон байна.	ХӨСҮТ	Аймаг, дүүргийн эмнэлэг, ДЭМБ
2.9	Тэсвэржсэн нянгийн тайланг жилд 2 удаа гаргаж ЭМБ-уудад мэдээлэх	+	+	+	+	+	Илэрсэн тэсвэржсэн бичил биетний тоо	Тайлан нийт 6-аас доошгүй гарч эрүүл мэндийн байгууллагад хүргэгдсэн байна.	ХӨСҮТ	Эрүүл мэндийн байгууллагууд
2.10	Хүн, мал эмнэлгийн нян судлалын лабораториудыг ББТ-ийн чанарын гадаад үнэлгээнд хамруулах	+	+	+	+	+	Үнэлгээнд хамрагдсан лабораторийн тоо	Үнэлгээнд хамрагдсан байна.	ХӨСҮТ, ЗӨСҮТ, МЭЕГ	ЭМЯ, ХХААХҮЯ, ДЭМБ, ДМАЭМБ

2.11	Бичил биетний эсрэг эмэнд мэдрэг чанарыг шинжлэх стандарт арга зүй, менежмент болон чанарын баталгаажуулалтын чиглэлээр лабораторийн шинжээчдийг чадавхижуулах	-	+	+	-	Сургалтад хамрагдсан мэргэжилтний тоо	Лабораторийн мэргэжилтнүүдийн 50-иас доошгүй хувийг сургалтад хамруулж, чадавхийг дээшлүүлсэн байна.	МЭЕГ	ХХААХҮЯ, ЭМЯ, Кодексийн Үндэсний зөвлөл
2.12	Газар тариалангийн ургамал өвчлүүлдэг гол эмгэг төрүүлэгчдийг хамруулан ББТ-ийн тандалтыг хийх	+	-	+	-	Хийгдсэн тандалтын тоо	Тандалтын тайлан, зөвлөмжийг холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.	ХХААХҮЯ	УХЭШХ, МХЕГ
Зорилт 3: Бичил биетний эсрэг эмийн хэрэглээг хянах, зохисгүй хэрэглээг бууруулах, эрүүл мэндийн байгууллагын бичил биетний тэсвэржилттэй тэмцэх хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх замаар хариуцлагатай хэрэглээг бий болгох.									
3.1	Мал, амьтанд хэрэглэсэн ББЭЭ-ийн хэрэглээг ДМАЭМБ-ын шатлалын дагуу тооцоолж, тайлагнах	+	+	+	+	Мал, амьтанд хэрэглэж буй ББЭЭ-ийн нэр төрөл, тоо	Тайланг олон улсын байгууллагад илгээсэн байна.	МЭЕГ	ХХААХҮЯ, ЭМЯ

3.2	Эрүүл мэндийн салбарт ББЭЭ-ийн хэрэглээний судалгааг жил бүр гаргаж, ЭМБ-ууд болон бүсийн төвд мэдээлэх	+	+	+	+	Импорттоор оруулсан болон дотоодод үйлдвэрлэсэн ББЭЭ-ийн тоо	Улсын хэмжээнд хэрэглэж буй ББЭЭ-ийн нэгдсэн дүнтэй болж, бүсийн бусад орны үр дүнтэй харьцуулсан байна.	ЭЭХХЗГ	ЭМЯ, ДЭМБ, Судалгааны байгууллагууд
3.3	Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвар үүсгэж буй ББТ-д тандалт судалгаа хийх	-	+	+	+	Тандалтын тайлан	Судалгааны дүнд үндэслэн гарсан дүгнэлт, зөвлөмжийг холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.	ХӨСҮТ	ЭЭХХЗГ, ЭМБ-ууд
3.4	"Жороор олгох мал, амьтны эмийн жагсаалт, журам"-ыг боловсруулж батлуулах	+	-	-	-	Журам-1, жагсаалт-1	Журам, жагсаалт батлагдаж, нийтэд түгээгдсэн байна.	МЭЕГ	Малын эмийн зөвлөл
3.5	Мал эмнэлгийн салбарт ББЭЭ-ийг борлуулах, хэрэглэх, устгах, хянах, мэдээлэх, зураглал гарган мэдээллийн сан үүсгэх	-	+	+	+	Зураглал, мэдээллийн сан	ББЭЭ-ийн эргэлтийн мэдээлэл жил бүр гардаг болно.	МЭЕГ	МЭЭСБУЛ, МХЕГ, Малын эм ханган нийлүүлэгч байгууллага, Малын эмийн сан

3.6	Эмнэлгийн байгууллагын антибиограмд үндэслэн эмчилгээнд антибиотикийг сонгон хэрэглэж буй байдалд үнэлгээ хийх	+	-	+	-	+	Үнэлгээнд хамрагдсан байгууллагын тоо	Үнэлгээний дүнд үндэслэн гарсан дүгнэлт, зөвлөмжийг холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.	ЭЭХХЗГ	Эрүүл мэндийн байгууллагууд
3.7	ББЭЭ үйлдвэрлэдэг дотоодын бүх үйлдвэрт GMP шаардлага хангуулах, нь хэрэгцээнд тохируулан тасралтгүй сургалт явуулах	-	+	+	+	+	GMP гэрчилгээ авсан үндэсний үйлдвэрийн тоо	ББЭЭ үйлдвэрлэдэг үндэсний эмийн бүх үйлдвэр GMP батламж авсан байна.	ЭЭХХЗГ	Эмийн үйлдвэрүүд, Сургалтын байгууллагууд, ТББ, холбоод
3.8	Ерөнхий нэршлийн ББЭЭ-ийг улсын бүртгэлд бүртгэхэд биоэквивалент чанарын тодорхойлолтыг оруулах	+	+	+	+	+	Тушаалд орсон заалтын тоо	Тушаал батлагдсан байна.	ЭЭХХЗГ	Эм хангамжийн байгууллагууд

3.9	Эмнэлэгт хэрэглэгдэж ББЭЭ-ийн хэрэглээнд тандалт судалгаа хийх	-	+	+	+	+	Хийгдсэн тандалтын тоо	Судалгааны дүнд үндэслэн гарсан дүгнэлт, зөвлөмжийг холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.	ЭЭХХЗГ	Эрүүл мэндийн байгууллагууд
3.10	ЭМБ-уудад ББТ-ийг бууруулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх, ОУБ-аас зөвлөх урьж ажиллуулах	+		+	+	+	Хөтөлбөрийг хэрэгжүүлсэн ЭМБ-уудын тоо	Төв эмнэлэг, төрөлжсөн мэргэжлийн бүх эмнэлэг хөтөлбөрийг нэвтрүүлсэн байна.	ЭЭХХЗГ	Төв эмнэлэг, төрөлжсөн мэргэжлийн бүх эмнэлэг
3.11	Нийтийн үйлчилгээтэй эмийн сангаар нянгийн эсрэг эмийг жоргүй олгох үйл ажиллагааг төвшинд таслан зогсоох	+		+	+	+	Хийгдсэн хяналт, шалгалтын тоо	Нийтийн үйлчилгээтэй бүх эмийн сан антибиотикийг жороор олгодог болсон байна.	ЭЭХХЗГ, МЭЕГ, Эм холбоо	МХЕГ
3.12	Мах, сүүнд ББЭЭ-ийн үлдэгдлийн тандалтыг хийх	+		+	+	+	Тандалтын тайлан	Тандалтын дүнд үндэслэн гарсан дүгнэлт, зөвлөмжийг холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.	МЭЕГ	УМЭАЦЛ, ХАБУЛЛ, Сургалт, судалгааны байгууллагууд, аймаг, нийслэлийн лабораторууд,

Зорилт 4: Халдварын сэргийлэлт, хяналтыг сайжруулан, байгаль орчны бохирдлоос сэргийлэх арга хэмжээ авч, халдварын тархалтыг зогсоох

4.1	Эрүүл мэндийн ажилтнуудад ББТ, халдварын сэргийлэлт хяналтын чиглэлээр сургалт зохион байгуулах	+	+	+	+	+	+	Сургалтад хамрагдсан эрүүл мэндийн ажилтны тоо	Сургалт зохион байгуулагдаж, эмч нарын мэдлэг дээшилнэ.	ЭМЯ, ХӨСҮТ	АШУУИС
4.2	Эм, эмчилгээний чанарын хяналтын байцаагчдын ББТ, халдварын сэргийлэлт хяналтын чиглэлээр хяналт хийх чадавхийг сайжруулах	+	+	+	+	+	+	Сургалтад хамрагдсан байцаагчийн тоо		ЭЭХХЗГ, МЭЕГ, МХЕГ, ЭМДЕГ	ЭМЯ, АШУУИС, ХХААХҮЯ, ОУБ
4.3.	Бичил биетний эсрэг эмийн зохистой хэрэглээг хэвшүүлэх удирдамжийг олон улсын стандартад /Нэг эрүүл мэнд/ үндэслэн боловсруулах	+	+	+	-	-	-	Ашигласан олон улсын удирдамжийн тоо Боловсруулсан удирдамж	Удирдамж/Гарын авлага холбогдох мал эмнэлгийн байгууллагад түгээгдсэн байна.	ХХААХҮЯ	ЭМЯ

4.4	Эрүүл мэндийн ажилтнуудад зориулсан халдварын сэргийлэлт, хяналтын мэдээлэл, сургалт, сурталчилгааны материал боловсруулах	+	+	-	-	Сургалт, сурталчилгааны материалын тоо	Сурталчилгааны материал эрүүл мэндийн байгууллагуудад түгээгдсэн байна.	ЭМЯ, ХӨСҮТ	Олон улсын байгууллага
4.5	Эрүүл мэндийн байгууллагуудад халдварын сэргийлэлт хяналтын чиглэлээр дэмжлэгт хяналт үнэлгээ хийх	+	+	+	+	Дэмжлэгт хяналт үнэлгээнд хамрагдсан байгууллагын тоо	Үнэлгээний дүнд үндэслэн гарсан дүгнэлт, зөвлөмжийг холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.	ЭМЯ, ХӨСҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ
4.6	Эмнэлгийн зөөлөн эдлэлийн ариутгал, халдваргүйтгэлийн тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх	+	+	+	+	Ариутгал халдваргүйтгэл ийн тоног, төхөөрөмжийн тоо	Зөөлөн эдлэлийн ариутгал, халдваргүйтгэл сайжирсан байна.	Эрүүл мэндийн байгууллага	-
4.7	Үйлчлүүлэгчийн хувцас, ор, дэрний даавууны нөөцийг бэлтгэн хэвтэн эмчлүүлэгчийг бүрэн хангах	+	+	+	+	Хувцасны тоо, ор дэрний даавуу, зөөлөн эдлэлийн нөөц	Дотоодын нөөцөөр үйлчлүүлэгчийн хувцас, даавууг бүрэн шийдсэн байна.	Эрүүл мэндийн байгууллага	-

4.8	Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвар үүсгэж буй ББТ-д тандалт судалгаа хийх	-	+	-	+	Тандалтын тайлан	Судалгааны дүнд үндэслэн гарсан дүгнэлт, зөвлөмжийг холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.	ХӨСҮТ	АШУҮИС, ЭМБ-ууд
Зорилт 5: Бичил биетний тэсвэржилтийн талаарх мэдээллийг олон нийтэд түгээх, боловсролын хөтөлбөрт оруулах, мэдлэг хандлагыг дээшлүүлэх, зохистой дадлыг сайжруулах замаар бичил биетний тэсвэржилтээс урьдчилан сэргийлэх, бууруулах									
5.1	ББТ, эмийн зохистой хэрэглээний талаарх иргэдийн мэдлэг, хандлага, дадлыг жил бүр үнэлж, үнэлгээний үр дүнд үндэслэн сургалт сурталчилгааны төлөвлөгөө гаргаж ажиллах	+	+	+	+	Төлөвлөгдсөн үйл ажиллагааны тоо	Төлөвлөгөөний дагуу сургалт сурталчилгаа хийгдсэн байна.	ЭЭХХЗГ, МЭЕГ	ЭМЯ, ХХААХҮЯ, БШУЯ, НЭМҮТ, судалгааны байгууллагууд, ОНХМБ-ууд
5.2	Хүний эрүүл мэндийн болон мал эмнэлгийн ББТ-ийн талаарх мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр төлөвлөгөөний дагуу түгээх	+	+	+	+	Мэдээллийн тоо	Олон нийтийн мэдлэг дээшилсэн байна.	ЭЭХХЗГ, МЭЕГ	ЭМЯ, ХХААХҮЯ, ТББ-ууд

5.3	ББТ болон ББЭЭ-ийн хэрэглээний тухай олон нийттэй харилцах стратеги баримт бичиг боловсруулах	-	+	-	-	-	Олон нийттэй харилцах стратеги баримт бичиг боловсруулж батлагдсан байна.	Баримт бичиг холбогдох оролцогч талуудад түгээгдсэн байна.	ОУ-ын байгууллагууд МЭЕГ, ЭЭХХЗГ	ХХААХҮЯ, ЭМЯ
5.4	ББЭЭ-ийн мэдлэг хандлагыг дээшлүүлэх дэлхийн 7 хоногийг зохион байгуулах	+	+	+	+	+	Зохион байгуулсан сургалт, сурталчилгааны тоо	Удирдамжийн дагуу үйл ажиллагаа зохион байгуулсан байна.	ЭЭХХЗГ, МЭЕГ	ЭМЯ, ХХААХҮЯ
5.5	ББТ-ийн асуудлыг Дэлхийн бусад тэмдэглэлт өдрүүдтэй холбох, тэмдэглэх	+	+	+	+	+	Хөтөлбөрт нь ББТ-ийн сэдэв орсон тэмдэглэлт өдрийн тоо	Удирдамжийн дагуу үйл ажиллагаа зохион байгуулсан байна.	ЭЭХХЗГ, МЭЕГ, НЭМҮТ	ОУБ-ууд
5.6	ББЭЭ-ийн зохистой хэрэглээний сарын аяныг эмнэлгүүдэд тодорхой хуваарийн дагуу жил бүр зохион байгуулах	+	+	+	+	+	Аяныг зохион байгуулсан эрүүл мэндийн байгууллагын тоо	Удирдамж, хуваарийг батлан эрүүл мэндийн байгууллагад хүргүүлсэн байна.	ЭЭХХЗГ	Эрүүл мэндийн байгууллагууд
5.7	ББТ-ийн эдийн засгийн дарамтыг (burden)-ыг тодорхойлох арга, аргачлалд суралцах	-	+	+	-	-	Сургалтад хамрагдсан мэргэжилтний тоо	Мэргэжилтнүүдийн мэдлэг дээшилж, үндэсний төвшинд эдийн засгийн ачаалал (burden)-ыг тодорхойлох	ЭЭЗХХГ, МЭЕГ	ЭМДЕГ, Их дээд сургууль, Сонгогдсон эмнэлгүүд

5.8	Хүний болон малын эрүүл мэндийн ажилтны ББТ-ийн талаарх мэдлэг, хандлага, дадлыг үнэлэх	-	+	+	-	Үнэлгээний тоо	чадвартай болсон байна.	ЭЭХХЗГ, МЭЕГ	ЭМБ-ууд
5.9	Малчид, тариаланчдад юуны? сайн дадал олгох, ББЭЭ-ийг хэрэглэх мэдлэг, хандлага, дадал олгох сургалтын хөтөлбөр боловсруулах	+	+	-	-	Зохион байгуулагдсан сургалтын тоо	Хөтөлбөрийн дагуу сургалт зохион байгуулагдсан байна.	ХХААХУЯ, МЭЕГ, ХААИС	Сургалтын байгууллагууд
5.10	Малын эмчийн төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөрт ББТ, ББЭЭ-ийн хэрэглээний дэд сэдвүүдийг оруулах	-	+	+	-	Олгогдсон кредитийн тоо	Сургалтын хөтөлбөрт тусч, мэргэжилтнүүдийн мэдлэг дээшилсэн байна.	ХААИС, БШУЯ	МЭЕГ, ЭЭХХЗГ, Их дээд сургуулиуд, ТББ-ууд
5.11	Талбарын тархвар судлалын лабораторийн сургалтын хөтөлбөрт ББТ-ийн тандалт, оношлогооны арга зүйн агуулгыг тусгах	-	+	+	-	Хөтөлбөрт тусгагдсан кредит цагийн тоо	Сургалтын хөтөлбөрт тусч, оюутнуудын мэдлэг дээшилсэн байна.	ХӨСҮТ	ЭЭХХЗГ

5.12	Өрх, сумын эмч нарт эмийн зохистой хэрэглээ, жор бичилт, ББТ-ийн хор уршгийн талаар тусгайлсан кредиттэй сургалтыг жил бүр явуулах	+	+	+	+	+	Кредит олгосон эмчийн тоо	Эмч нарын мэдлэг дээшилсэн байна.	ЭЭХХЗГ, ЭМХТ, ӨАУМХ	НЭМҮТ, Их дээд сургууль
5.13	Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт эмийн зохистой хэрэглээ, ББТ-ийн хор хөнөөлийн талаар тусгуулах санал боловсруулах	-	+	+	+	-	Хөтөлбөрт тусгах үйл ажиллагааны тоо	Саналыг боловсруулж БШУЯ-д хүргүүлсэн байна.	ЭЭХХЗГ, МЭЕГ	БШУЯ
5.14	ББТ, ББЭЭ-ийн зохистой хэрэглээний талаар орон нутгийн болон үндэсний хэмжээний сургалтуудыг зохион байгуулж, бүртгэлжүүлэх	-	+	+	+	+	Зохион байгуулагдсан сургалтын тоо	Хөтөлбөрийн дагуу сургалт зохион байгуулагдсан байна.	МЭЕГ	Сургалтын байгууллагууд